



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБАНЫ  
ТӨМӨР ЗАМ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Тооллогын комисс байгуулах тухай

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2 дахь хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код 136/-ийн 136.5.2-ын "г" дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тус газрын эд хөрөнгийг 2020 оны хагас жилийн байдлаар тооллого хийх комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: Цагдаагийн хошууч Н.Пүрэвсүрэн  
Замын цагдаагийн тасгийн дарга  
Нарийн бичгийн дарга: Цагдаагийн ахлах дэслэгч Г.Наранцацрал  
Нягтлан бодогч /гэрээт/  
Гишүүд: Цагдаагийн ахлах дэслэгч Н.Батжаргал  
Ахлах хэрэг бүртгэгч  
Цагдаагийн ахлах дэслэгч Ч.Ганбаатар  
Холбоо мэдээллийн инженер  
Цагдаагийн дэслэгч О.Бадрах  
Мөрдөгч  
Цагдаагийн дэслэгч Э.Наранзул  
Аж ахуйн ажилтан  
Цагдаагийн дэд ахлагч А.Гэрэлтуяа  
Эрүүлжүүлэх байрны цагдаа

2. Газрын үндсэн болон эргэлтийн эд хөрөнгийг тоолох ажлыг 06 дугаар сарын 02-ны өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрийн хооронд чанартай зохион байгуулж, дүнг газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулахыг комиссын дарга, /цагдаагийн хошууч Н.Пүрэвсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд танилцуулсугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

ХУУЛБАР ҮНЭН: Захиргааны удирдлагын тасгийн дарга

цагдаагийн дэд хурандаа

Д.БАТСАЙХАН

С.БАЯРБАТ

D:\Documents\Tushaal2020\A4.docx

0089571 СБТ-4-10574 1119265667

001400328